**МОНГОЛ УЛС**
**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2018 оны 06 сарын 25 өдөр Дугаар А/234 Чингис хот

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.5, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Газрын кадастрын мэдээллийн сан”-г солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд “Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх” ажил хэрэгжсэнтэй холбогдуулан хавсралтад дурдагдсан 2 аж ахуйн нэгжид 4882 $м^2$ газрыг эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшиж буй аж ахуйн нэгжүүдийн газрын кадастрын зураглалыг хавсралтаар баталсугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, гэрээний биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Д.Баярхүү/-т үүрэг болгосугай.

4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийг гаргасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2003 оны 211 дүгээр захирамжийн хавсралтын 6, 9 дэх хэсгийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА Н.ГАНБЯМБА

D:\My Documents\Захирамж 2018.doc

Аймгийн Засаг даргын 2018 оны
..06.... дугаар сарын ..23...өдрийн ..А/234..
дугаар захирамжийн хавсралт

| Эзэмшигч хуулийн этгээдийн | | Өмнөх | | | | | | Газрын | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Захи | | эзэмжийн | | Газрын | | | | | | |
| Нэр | Регистрийн дугаар | Огноо | Дугаар | Хавсралтын дугаар | Холбогдох хэсгийн дугаар | Нэгж талбарын дугаар | Хэмжээ /м²/ | Нэгж талбарын дугаар | Хэмжээ /м²/ | Байршил | Ашиглалтын зориулалт | Эзэмшүүлэх хугацаа |
| 1 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| “Баян-Өндөр манал” ххк | 2644533 | 2003-12-26 | 211 | - | 6 | 221601507 | 691 | | 1081 | Хэрлэн сум, 4-р баг, Тэмүүжин гудамж, А-46 тоот | Худалдаа, үйлчилгээ | 45 |
| “Хурх чандмань” ХХК | 2644797 | 2003-12-26 | 211 | - | 9 | 221601510 | 2603 | | 3801 | Хэрлэн сум, 1-р баг, Тэмүүжин гудамж, Ж-02 тоот | Худалдаа, үйлчилгээ | 45 |

5. Энэхүү захирамжийг гаргасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2003 оны 211